



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А1340

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.10 дахь заалтууд, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.11.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 71 дүгээр Тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Улсын болон орон нутгийн төсвийн орлогын суурь баазыг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн талаар олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор зохион байгуулах "Татвар төлөгчдийн өдрүүд-2024" арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2.Арга хэмжээний зардалд шаардагдах 22,000,000 (хорин хоёр сая) төгрөгийг батлагдсан эх үүсвэрээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

3.Батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж, үр дүнг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд тайлагнахыг аймгийн Татварын газар (Н.Энхтуяа)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын
2024. оны 08 дүгээр сарын 08 ний өдрийн
А/340 дугаар захирамжийн хавсралт

"ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ӨДРҮҮД-2024"
АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН
ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Мөнгөн дүн	Нийт дүн	
1	Аймгийн шилдэг татвар төлөгч /ТОП-10/	10	1,000,000	10,000,000	
2	Сумдын шилдэг татвар төлөгч /И-баримт хэвлэлтээр/	17	200,000	3,400,000	
3	Хүүхдийн уралдааны шагналд	1-р байр	3	120,000	360,000
		2-р байр	3	100,000	300,000
		3-р байр	3	80,000	240,000
		Тусгай байр	3	60,000	180,000
4	Reel шагнал	1-р байр	1	150,000	150,000
		2-р байр	1	120,000	120,000
		3-р байр	1	100,000	100,000
5	Сумдад ажиглах шатахуун	300	4,200	1,260,000	
6	Анонос			1,900,000	
7	Мессеж хүргүүлэх			1,500,000	
8	Сургалтын цайны материал			990,000	
9	Тэмцээн уралдаан			1,500,000	
НИЙТ ДҮН				22,000,000	

__оОо__